

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Бичилманал ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/089/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 11315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Баян ташаагийн эх аудит ХХК-ийн захирал: Т.Хоролсүрэн Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 943

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
БИЧИЛ МАНАЛ ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙНТӨВИЙН ДАРГА
А.ЦЭНД-АЮУШ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Бичилманал өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 477.7 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлж гүйцэтгэлээр 326.7 сая төгрөгийн, дархлаажуулалтын зардалд Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас 2.5 сая төгрөгийн, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 11.4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Бичил манал ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 95.9 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 96.3 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,621,046.16	6,220,034.98
1.1.2	Дансны авлага	85,727,525.66	7,440,961.90
1.1.3	Татвар, НД-н шимтгэлийн авлага		
1.1.6	Бараа материал	44,089,525.58	39,028,945.47
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	132,438,097.40	52,689,942.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	156,872,335.57	127,619,549.43
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	156,872,335.57	127,619,549.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	289,310,432.97	180,309,491.78
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өглөг		
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч	28,061,385.00	28,061,385.00
2.3.1	Өмч: - төрийн	27,947,385.00	27,947,385.00
2.3.2	- хувийн	114,000.00	114,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	407,864.00	407,864.00
2.3.7	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	260,841,183.98	151,840,242.78
	Өмнөх үеийн үр дүн		260,841,183.98
	Тайлант үеийн үр дүн		(109,000,941.20)
2.3.11	Эздийн өмчийн дүн	289,310,432.98	180,309,491.78
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	289,310,432.98	180,309,491.78

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	817,445,964.67	726,139,776.50
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	817,445,964.67	726,139,776.50
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	2,051,361.62	574,730.81
6	Бусад орлого	50,727,300.00	17,691,067.50
7	Ерөнхий ба удирдлагын зардал	812,098,924.02	853,349,042.93
9	Бусад зардал		
11	Бусад ашиг (алдагдал)		-
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	58,125,702.27	(108,943,468.12)
13	Орлогын татварын зардал / (буцаалт)	205,136.16	57,473.08
14	Татварын дараах ашиг (алдагдал)	57,920,566.11	(109,000,941.20)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	57,920,566.11	(109,000,941.20)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	28,061,385.00	407,864.00	202,920,617.86	231,389,866.86
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал			57,920,566.11	57,920,566.11
2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	28,061,385.00	407,864.00	260,841,183.98	289,310,432.98
Залруулсан үлдэгдэл	28,061,385.00	407,864.00	260,841,183.98	289,310,432.98
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал			(109,000,941.20)	(109,000,941.20)
2025 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	28,061,385.00	407,864.00	151,840,242.78	180,309,491.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	773,695,331.63	818,401,051.07
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	767,671,470.01	804,426,340.26
1.1.4	Бусад мөнгөн орлого	6,023,861.62	13,974,710.81
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	781,153,865.46	806,971,237.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	446,052,154.03	452,607,479.20
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	130,888,063.42	133,443,968.54
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	105,541,079.17	147,447,822.52
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн	247,000.00	411,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	47,551,708.84	48,187,192.99
1.2.9	Бусад мөнгөн зарлага	50,873,860.00	24,873,774.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,458,533.83)	11,429,813.82
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,937,400.00	7,830,825.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,937,400.00	7,830,825.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,937,400.00)	(7,830,825.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(17,395,933.83)	3,598,988.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,016,979.99	2,621,046.16
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,621,046.16	6,220,034.98

3. АУДИТЫН ИЛЭРҮҮЛЭЛТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Бичил манал ӨЭМТ нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг дүнтэй алдаа, зөрчил илрээгүй болно.